



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Яруу сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/185/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай хот
2022 он

Төрийн аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн
Утас: 99014227
Цахим хаяг: dagvasurend@audit.gov.mn

Аудитор: Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга /мянган төгрөг/.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
4. Аудитын илрүүлэлт	11
4.2.1 Залруулсан алдаа	11
4.2 .2 Төлбөрийн акт	11
4.2.3 Албан шаардлага	11
4.2.4 Зөвлөмж.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1302/176

танай _____ -ны № _____ -т

БЯАНХАЙРХАН СУМЫН
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Б.ЖАРГАЛСАЙХАН-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхайрхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхайрхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013023097

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	31765750.00	27190410.00
35	БАРАА МАТЕРИАЛ	31765750.00	27190410.00
354	Хангамжийн материал	31765750.00	27190410.00
35410	Бичиг хэргийн материал	169000.00	139700.00
35420	Аж ахуйн материал	21326010.00	22495510.00
35440	Түлш, шатах тослох материал	10270740.00	4555200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	374028419.32	366714287.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	374028419.32	366714287.11
392	Биет хөрөнгө	366392619.32	359078487.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	377347000.00	377347000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35642058.61	-50722000.04
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	24414672.40	25414672.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-17748672.40	-20813084.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17562586.95	20534865.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13934458.53	-15819167.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	8600000.00
39217	Ном	14393549.51	14536200.51
393	Биет бус хөрөнгө	7635800.00	7635800.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7635800.00	7635800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	405794169.32	393904697.11
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	435345.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	435345.00
413	Өглөг	0.00	435345.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	435345.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	405794169.32	393469352.11
51	Засгийн газрын хувь оролцоо	405794169.32	393469352.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	47794786.30	47794786.30
51101	Өмч: - төрийн	47794786.30	47794786.30
512	Хуримтлагдсан үр дүн	347159113.90	334834296.69
51210	Өмнөх үеийн үр дүн	2754004.82	347159113.90
51220	Тайланг үеийн үр дүн	344405109.08	-12324817.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10840269.12	10840269.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	405794169.32	393904697.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	409708649.00	88148629.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	342034349.00	12664929.50
120	Нийтлэг татварын бус орлого	342034349.00	12664929.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	342034349.00	12664929.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	342034349.00	12664929.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67674300.00	75483700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	75483700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	75483700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67674300.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67674300.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	65303539.92	100473446.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65303539.92	100473446.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63174607.92	100315494.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47536228.00	53318907.00
210101	Үндсэн цалин	47536228.00	53318907.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6140239.00	7040812.00
210201	Тэтгэврийн даатгал	4040583.00	4995639.00
210202	Тэтгэмжийн даатгал	802118.00	536458.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	380288.00	429686.00
210204	Ажилгүйдлийн даатгал	83385.00	102714.00
210205	Эрүүл мэндийн даатгал	833865.00	976315.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5257468.00	17993314.00
210301	Гэрэл, цахилгаан	107468.00	727970.00
210302	Түлш, халаалт	5150000.00	17235344.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	30000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	715600.00	675600.00
210401	Бичиг хэрэг	181600.00	97700.00
210402	Тээвэр, шатахуун	262400.00	216300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235400.00	235000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36200.00	126600.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	168000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	168000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	901293.00	1089800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	901293.00	959800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	130000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2623779.92	20029061.71
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2623779.92	20029061.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2128932.00	157952.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2128932.00	157952.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2128932.00	157952.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	344405109.08	-12324817.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	344405109.08	-12324817.21

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	42,650,986.30	10,840,269.12	2,754,004.82	0.00	56,245,260.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,143,800.00	0.00	0.00	0.00	5,143,800.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	47,794,786.30	10,840,269.12	2,754,004.82	0.00	61,389,060.24
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	47,794,786.30	10,840,269.12	2,754,004.82	0.00	61,389,060.24
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	344,405,109.08	0.00	344,405,109.08
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,589,572.60	21,680,538.24	349,913,118.72	0.00	467,183,229.56
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	95,589,572.60	21,680,538.24	349,913,118.72	0.00	405,794,169.32
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,589,572.60	21,680,538.24	349,913,118.72	0.00	405,794,169.32
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	47,794,786.30	10,840,269.12	347,159,113.90	0.00	405,794,169.32
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	-12,324,817.21	0.00	-12,324,817.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,794,786.30	10,840,269.12	334,834,296.69	0.00	393,469,352.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	67674300.00	75483700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	67674300.00	75483700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	75483700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	75483700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67674300.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67674300.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	67624300.00	75433700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	67624300.00	75433700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65495368.00	75275748.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	47182800.00	52931278.00
210101	Үндсэн цалин	47182800.00	45654887.00
210102	Нэмэгдэл	0.00	7276391.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6369800.00	6993096.00
210201	Тэтгэврийн даатгал	4270144.00	4947923.00
210202	Тэтгэмжийн даатгал	802118.00	536458.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	380288.00	429686.00
210204	Ажилгүйдлийн даатгал	83385.00	102714.00
210205	Эрүүл мэндийн даатгал	833865.00	976315.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10097468.00	12476774.00
210301	Гэрэл, цахилгаан	107468.00	727970.00
210302	Түлш, халаалт	9960000.00	11718804.00
210303	Цэвэр, бохир ус	30000.00	30000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	564700.00	564300.00
210401	Бичиг хэрэг	63000.00	63000.00
210402	Тээвэр, шатахуун	216300.00	216300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235400.00	235000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50000.00	50000.00
2105	Нормативт зардал	95600.00	95600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95600.00	95600.00
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	0.00	150000.00
210604	Урсгал засвар	0.00	150000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	168000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	168000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1185000.00	1896700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1055000.00	1766700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	130000.00	130000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2128932.00	157952.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2128932.00	157952.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2128932.00	157952.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	50000.00	50000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	50000.00	50000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	50000.00	50000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	50000.00	50000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50000.00	50000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-50000.00	-50000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74708400.00	75325748.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74708400.00	75325748.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74708400.00	75325748.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53353700.00	52931278.00
210101	Үндсэн цалин	48580300.00	45654887.00
210102	Нэмэгдэл	4773400.00	7276391.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7197900.00	6993096.00
210201	Тэтгэврийн даатгал	5062800.00	4947923.00
210202	Тэтгэмжийн даатгал	529800.00	536458.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	427200.00	429686.00
210204	Ажилгүйдлийн даатгал	106800.00	102714.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1071300.00	976315.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10971500.00	12476774.00
210301	Гэрэл, цахилгаан	1351500.00	727970.00
210302	Түлш, халаалт	9590000.00	11718804.00
210303	Цэвэр, бохир ус	30000.00	30000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	614700.00	614300.00
210401	Бичиг хэрэг	63000.00	63000.00
210402	Тээвэр, шатахуун	216300.00	216300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	235400.00	235000.00
210404	Ном, хэвлэл	50000.00	50000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50000.00	50000.00
2105	Нормативт зардал	95600.00	95600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	95600.00	95600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	150000.00	150000.00
210604	Урсгал засвар	150000.00	150000.00
2107	Томилолт, зочны зардал	281700.00	168000.00
210702	Дотоод албан томилолт	281700.00	168000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2043300.00	1896700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1913300.00	1766700.00
210802	Аудиг, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	130000.00	130000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74708600.00	75325748.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	74708600.00	75325748.00
122005	Орон нутгийн төсвөөс	74708600.00	75325748.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.00	5.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.00	3.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00
620004	Гэрээт ажилтан		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Г.Баасанжаргал гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Яруу сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Яруу сумын Соёлын төвийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар товч тодорхойллоо. Үүнд:

Эрхэм зорилго:

Нутгийн иргэдийн оролцоо, тэдний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчинд тулгуурласан бие даасан чөлөөтэй хөгжих соёлын орчинг бий болгоход оршино.

Үйл ажиллагаа:

Соёлын төв нь Түүх соёлын дурсгалт өвийг илрүүлэх бүртгэлжүүлэн хамгаалах, соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийг нээн илрүүлж тэднийг сурталчилах өвлүүлэн уламжлуулах, мартагдсан болон уламжлалт соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдэд чиглэсэн соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулах, сургалт дамжаа хичээллүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Яруу сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 88,148.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,322.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 991.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0	0	0.00
Бараа материал	31,765.70	27,190.40	-4,575.30
Үндсэн хөрөнгө	374,028.40	366,714.20	-7,314.20
Нийт хөрөнгө	405,794.10	393,904.60	-11,889.50
Өр төлбөр	0	435.3	435.30
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	405,794.10	393,469.30	-12,324.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	405,794.10	393,904.60	-11,889.50

Бараа материал дансны үлдэгдэл 4,575.3 мянган төгрөгөөр буурсан нь материалын худалдан авалт бага байсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,314.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 435.0 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 12,324.8 мянган төгрөг болж буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 74,708.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 74,708.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 75,483.7 мянган төгрөг, санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 75,433.7 мянган төгрөгийг зарцуулж, 157.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт муу, нярвын нэрийн дансанд их хэмжээний мөнгө төвлөрүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 137 мэдээллийг хугацаандаа оруулсан бөгөөд хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар түүвэр аудитад хамруулсан бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байх
2. Нярвын нэрийн дансанд төсвийн мөнгийг төвлөрүүлж, зарцуулалт хийсэн эсэх
3. Е-баримтгүй ажил, гүйлгээг данс бүртгэлд тусгасан эсэх
4. Цалингийн урьдчилгааг хавтгайруулж олгосон эсэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,354.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,064.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,290.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайланг 4,064.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн. Аудитын явцад залруулсан болно.

4.2.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.2.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага тогтоогоогүй болно.

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2,290.0 мянган төгрөгний худалдан авалтын е-баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.2, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын ерөнхий хуулийн 28.2 “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 “Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		2	6,354.9	1	4,064.9					1	2,290.0
	Дүн	2	6,354.9	1	4,064.9					1	2,290.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Дүн										
	Нийт дүн										

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АХЛАХ АУДИТОР

Б.ДАГВАСҮРЭН

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Г.БААСАНЖАРГАЛ